



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

Тендер шалгаруулалт
гэрээний нэр:

**ЦАХИЛГААН МОНТАЖ, УГСРАЛТАНД ШААРДЛАГАТАЙ
МАТЕРИАЛ /ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ/ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР**

Тендер шалгаруулалт
гэрээний дугаар:

ЭТТ/201901229

УЛААНБААТАР ХОТ
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Цахилгаан монтаж, угсралтанд шаардлагатай материал /засвар, үйлчилгээний/**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 04 сарын 04-ны 10:00 цагаас** өмнө **Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын www.tender.gov.mn цахим** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 04 сарын 04-ны 10:40** -т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“Эрдэнэс Таван толгой” ХК
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджав-8,
Финанс төв, 5 давхар 503 тоот,
Утас: 70118585 дотуур утас-565
Факс:70118464

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|---|
| ТӨӨЗ 1.1 | <ol style="list-style-type: none"> 1. Компанийн гэрчилгээний хуулбар 2. НӨАТ-ын гэрчилгээний хуулбар 3. Татварын цахим тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ 4. ШШГЕГ-ын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ 5. 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 6. 2018 онд хийж гүйцэтгэсэн 1-ээс доошгүй гэрээний хуулбар 7. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлвэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх 8. Тендерт санал болгосон хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын www.tender.gov.mn цахим хаягаар</p> <p>Огноо: 2019 оны 04 сарын 04 өдөр</p> <p>Цаг: 10:00</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p style="text-align: center;">Байгууллагын хаяг: “Эрдэнэс Таван толгой” ХК Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхар 503 тоот, Утас: 70118585 дотуур утас-565 Факс:70118464</p> <p>Огноо: 2019 оны 04 сарын 04 өдөр</p> <p>Цаг: 10:40</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p> |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Цахилгааны монтаж угсралтанд шаардлагатай материал /засвар үйлчилгээний/

1. Зорилго:

- Цахилгааны монтаж угсралтанд шаардлагатай захиалгын сэлбэг материал нь уурхайн цахилгааны хэвийн найдвартай ажиллагааг хангахад хэрэглэгдэх засвар үйлчилгээний өдөр тутмын шаардлагатай материалууд юм.

2. Үндсэн шаардлага:

Нийлүүлэгчид тавигдах шаардлага:

2.1 Нийлүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага

Дээрх төрлийн бараа материалыг худалдан борлуулдаг нийлүүлдэг туршлагатай байх. Бараа материал нь үйлдвэрийн гэмтэлтэй тохиолдолд буцаалт хийх буюу сольж өгдөг байх.

2.2 Чанар, стандарт

- Евро стандартын цахилгааны монтаж угсралтанд шаардлагатай материал нийлүүлэх компани нь чанар сайтай бараа материал худалдан нийлүүлэх.

2.3 Нийлүүлэх бараа материалын үйлдвэрлэгдсэн улс, өмнө нийлүүлж байсан эсэх туршлага

- Цахилгааны монтаж угсралтанд шаардлагатай материал нь евро стандартаар /ОХУ, Солонгос г.м дүйцэхүйц/ үйлдвэрлэгдсэн сайн чанартай байх.

3. Шаардагдах баримт бичиг:

3.1 Нийлүүлэгчээс шаардах тусгай зөвшөөрөл, стандартыг тогтоосон тусгай сертификат, бусад баримт бичиг

- Дээрх төрлийн материалыг нийлүүлэх компани нь үйлдвэрээс гаргасан техникийн тодорхойлолтын сертификатыг хавсарган өгөх.

3.2 Энэхүү ажил үйлчилгээ, бараа материалыг авснаар гарах эдийн засгийн тооцоо болон судалгаа үр ашигтай байдал

- Цахилгааны монтаж угсралтанд шаардлагатай захиалгын сэлбэг материал нь уурхайн цахилгааны хэвийн найдвартай ажиллагааг хангах юм.

3.4 Тухайн бараа материал, ажил, үйлчилгээнд шаардагдах захиалагчийн зүгээс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг болон нэмэлт шаардлагатай зүйлс

- Хавсралт 1

| № | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР / сэлбэг, барааны дугаар/ | Хэмжих нэгж / Тоо хэмжээ | | ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ |
|----|--|--------------------------|-----|--|
| | | | | |
| 1 | Хөргөлтийн хий | кг | 100 | R-22 /10кг савалгаатай/ |
| 2 | Хөргөлтийн хий | кг | 50 | R-410 /10кг савалгаатай/ |
| 3 | Рубельник | ш | 10 | 250А /гар таслуур, Орос/ |
| 4 | 1 фазын автомат | ш | 24 | 16А /евро стандарт/ |
| 5 | 1 фазын автомат | ш | 24 | 25А /евро стандарт/ |
| 6 | 1 фазын автомат | ш | 24 | 32А /евро стандарт/ |
| 7 | 2 фазын автомат | ш | 24 | 25А /евро стандарт/ |
| 8 | 2 фазын автомат | ш | 24 | 32А /евро стандарт/ |
| 9 | 2 фазын автомат | ш | 24 | 40А /евро стандарт/ |
| 10 | 3 фазын автомат | ш | 12 | 63А /евро стандарт/ |
| 11 | 3 фазын автомат | ш | 24 | 32А /евро стандарт/ |
| 12 | Цахилгаан соронзон пускатель | ш | 10 | 40А, 220В |
| 13 | Цахилгаан соронзон пускатель | ш | 10 | 80А, 380В |
| 14 | Цахилгааны удирдлагын стоп кноп | ш | 20 | Цахилгааны удирдлагын OFF кноп |
| 15 | Цахилгааны удирдлагын залгах кноп | ш | 20 | Цахилгааны удирдлагын ON кноп |
| 16 | Лед гэрэл | ш | 30 | Лед гэрэл 36Вт /нэмэх, сайн чанарын/ /Солонгос/ |
| 17 | Лед гэрэл | ш | 60 | Лед гэрэл 18Вт /хасах, сайн чанарын/ /Солонгос/ |
| 18 | Лед гэрэл | ш | 100 | 48Вт 60х60 дүүжин таазны лед гэрэл /Солонгос, чанар сайтай/ |
| 19 | Гэрлийн лед ламп | ш | 50 | 30Вт /энгийн резьбатай/ |
| 20 | Гэрлийн лед соронзтой лампы | ш | 50 | 20Вт /соронзтой дугуй/ |
| 21 | Гэрлийн лед ламп | ш | 80 | 18Вт /120см урттай, шууд 220В-д холбодог өдрийн лед лампы/ |
| 22 | Ил монтажийн хос разетка | ш | 50 | Усны хамгаалалтай ил монтажны хос разетка /орос / |
| 23 | Далд монтажийн хос разетка | ш | 50 | Далд монтажны хос разетка /орос/ |
| 24 | Ил монтажийн хос разетка | ш | 100 | Ил монтажны хос разетка /орос/ |
| 25 | Вилка /залгуур/ | ш | 200 | 2 сэрээт залгуур /сайн чанарын, евро стандарт/ |
| 26 | Зэс кабель | м | 600 | Кабель КГ-2х2,5мм ² /орос/ |

| | | | | |
|----|---|------|-----|--|
| 27 | Зэс кабель | м | 600 | Кабель КГ-2х4мм ² /орос/ |
| 28 | Зэс кабель | м | 300 | Дотор монтажийн уян зэс кабель 2х4мм ² /орос/ |
| 29 | Зэс кабель | м | 200 | Дотор монтажийн хатуу зэс кабель 2х2,5мм ² /орос/ |
| 30 | Зэс кабель | м | 300 | Дотор монтажийн уян зэс кабель 2х2,5мм ² /орос/ |
| 31 | Кабель | м | 500 | АВВГЗх16+1х6мм ² /орос/ |
| 32 | Цахилгаан халаагуурын кноп | ш | 50 | 2000Вт, 220В, 25А |
| 33 | Цахилгааны өнгийн лент | ш | 100 | Сайн чанарын зузаан ороодостой /Солонгос/ |
| 34 | Ус чийгний хар лент | ш | 50 | Ус чийгний хамгаалалттай хар лент |
| 35 | Фото реле | ш | 20 | 25А, /орос/ |
| 36 | Хөнгөн цагаан гилз | ш | 100 | Диаметр-50мм |
| 37 | Хөнгөн цагаан гилз | ш | 40 | Диаметр-95мм |
| 38 | Хөнгөн цагаан гилз | ш | 60 | Диаметр-120мм |
| 39 | Хөнгөн цагаан төгсгөвч | ш | 100 | Диаметр-50мм |
| 40 | Хөнгөн цагаан төгсгөвч | ш | 40 | Диаметр-95мм |
| 41 | Хөнгөн цагаан төгсгөвч | ш | 60 | Диаметр-120мм |
| 42 | Хөнгөн цагаан төгсгөвч | ш | 60 | Диаметр-35мм |
| 43 | Резин муфьт | ш | 5 | Хэмжээ: 35-70мм 0,4кВ |
| 44 | Резин муфьт | ш | 5 | Хэмжээ: 70-120мм 0,4кВ |
| 45 | Төгсгөлийн муфьт | ш | 5 | Хэмжээ: 70-120мм 10кВ |
| 46 | Дундын муфьт | ш | 5 | Хэмжээ: 70-120мм 10кВ |
| 47 | Шалны халаалтын карбон ялтас | мкв | 80 | Өргөн-1м сайн чанарын /Солонгос/ |
| 48 | Шалны халаалтын карбон ялтас холбогч клем | үүт | 1 | Шалны халаалтын карбон ялтас холбогч клем |
| 49 | Шалны халаалтын термистат | ш | 10 | УТН-170 |
| 50 | Ил монтажийн 1 даралттай унтраалга | ш | 100 | 16А /орос/ |
| 51 | Ил монтажийн 2 даралттай унтраалга | ш | 100 | 16А /орос/ |
| 52 | Далд монтажийн 1 даралттай унтраалга | ш | 50 | 16А /орос/ |
| 53 | Далд монтажийн 2 даралттай унтраалга | ш | 50 | 16А /орос/ |
| 54 | Кабелийн хар хоолой | боод | 4 | Диаметр-16мм /Солонгос/ |

| | | | | |
|----|--------------------------------------|------|----|---|
| 55 | Кабелийн хар хоолой | боод | 4 | Диаметр-22мм /Солонгос/ |
| 56 | Кабелийн хар хоолой | боод | 4 | Диаметр-40мм /Солонгос/ |
| 57 | Кабель далдлагч | Боод | 10 | Дөрвөлжин цагаан далдлагч. Хэмжээ-30x20мм |
| 58 | Кабель далдлагч | боод | 5 | Дөрвөлжин цагаан далдлагч. Хэмжээ-50x30мм |
| 59 | Кабель далдлагч | боод | 5 | Шаланд наадаг далдлагч. Хэмжээ-50x30мм |
| 60 | Цэнэг шавхагч | ш | 3 | ОПН, 10кВ |
| 61 | Лед прожектор | ш | 20 | 2ш оптик линзтэй лед прожектор 100Вт |
| 62 | Лед прожектор | ш | 15 | 3ш оптик линзтэй лед прожектор 150Вт |
| 63 | Цахилгаан тений термистат | ш | 50 | 1-12 хүртэл тохируулгатай цахилгаан тений термистат /KULEP-теньний/ |
| 64 | Цахилгааны нейтраль холбох багц клем | ш | 50 | Клем зэс жижиг |
| 65 | Цахилгааны нейтраль холбох багц клем | ш | 20 | Клем зэс том |
| 66 | 0,4кВ-ын гал хамгаалагч | ш | 15 | Гар салгуурын 400А-тай гал хамгаалагч 0,4кВ /евро стандарт/ |
| 67 | 0,4кВ-ын гал хамгаалагч | ш | 15 | Гар салгуурын 250А-тай гал хамгаалагч 0,4кВ / евро стандарт / |

2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл *[Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.]* гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** [Барааг хүлээж авах хаягийг бичнэ]

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|---|-------------|--|---|--|--------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Техникийн тодорхойлолтон заасан задаргаа нэршилээр | <i>Техникийн тодорхойлолт хэсэгт зааснаар</i> | <i>Техникийн тодорхойлолтод заасан тоо хэмжээгээр</i> | | “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжид жав-8, Финанс төв, 1 давхар 106 тоот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Улаанбаатар хот | Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоног | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоног | |
| | | | | | | | |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]¹** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² Алданги оногдуулах хувь: **Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,05 хувь**
Алдангийн нийт дүн: **Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 2.5 хувь**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

| ЗАХИАЛАГЧ | НИЙЛҮҮЛЭГЧ |
|-----------------|-----------------|
| _____ | _____ |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| _____ | _____ |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| _____ | _____ |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]